240

"БАГАНУУРЫН ДУЛААНЫ СТАНЦ" ТӨХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2022 оны 12 сарын 15 өдөр Дугаар А/82 Улаанбаатар хот

Журам батлах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дүгээр зүйлийн 20.1.10 дахь заалт, "Багануурын дулааны станц" ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн 21 дүгээр тогтоол. "Багануурын дулааны станц" ТӨХК-ийн Хөдөлмөрийн дотоод журмын 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1."Багануурын дулааны станц" ТӨХК-ийн ажилтнуудад "Сарын үйл ажиллагааны үр дүнгээр нэмэгдэл хөлс олгох журам"-ыг нэгдүгээр хавсралтаар, сарын үйл ажиллагааг дүгнэх үзүүлэлтийг хоёрдугаар хавсралтаар, ажиллагсдын сарын нэмэгдэл хөлс дүгнэх үзүүлэлтийг гуравдугаар хавсралтаар, "Багануурын дулааны станц" ТӨХК-ийн ажилтнуудад жилийн ажлын үр дүнгээр нэмэгдэл хөлс олгох журам"-ыг дөрөвдүгээр хавсралтаар тус тус баталсугай.

2.Батлагдсан журмуудыг компанийн нийт ажилтнуудад танилцуулж, үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг хэсэг, нэгжийн удирдлагуудад үүрэг болгосугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Н.ГАНБААТАР

УЛААНБААТАР ХОТ БАГАНУУРЫН ДУЛААНЫ СТАНЦ ТӨХК АТА6801 2688794 2722010001

241

"Багануурын дулааны станц"ТӨХК-ийн
Гүйцэтгэх захирлын 2011 оны 12 сарын
15-ны өдрийн 11/192 тушаалын 1-р хавсралт

"Багануурын дулааны станц" ТӨХК-ийн ажилтнуудад сарын үйл ажиллагааны үр дүнгээр нэмэгдэл хөлс олгох журам

Нэг. Журмын зорилго

1.1 Компанийн төлөвлөгөөт зорилтуудыг ханган биелүүлэх, үр ашгийг нэмэгдүүлэх, алдагдлыг бууруулах, өмч хөрөнгийн ашиглалт, хамгаалалтанд тавих хяналтыг сайжруулах, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагыг хангах, технологийн авааръ саатал, зөрчилгүй ажиллах, ажилтан нэг бүрийн бүтээлч идэвхийг өрнүүлэхэд энэхүү журмын зорилго чиглэгдэнэ.

Хоёр. Нэмэгдэл хөлс олгох нөхцөл

2.1 Үйлдвэрт ноцтой осол, авааръ, технологийн зөрчил гараагүй бол тухайн сарын нэмэгдэл хөлсийг доорхи үзүүлэлтүүдээр 50 хүртэл хувиар олгож болох ба Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрт тусгагдсан хувь хэмжээгээр олгоно.

Гурав. Нэмэгдэл хөлс олгох үзүүлэлт, түүний хэмжээ

3.1 Нэмэгдэл хөлсийг дүгнэх үзүүлэлт нь "Багануурын дулааны станц" ТӨХК-ийн зорилтот түвшингийн үндсэн 15 үзүүлэлт байх бөгөөд хавсралтад тусгасан уг үзүүлэлтийн биелэлтийн хувиар хувилж тооцно./Хавсралт №1/

Дөрөв. Дүгнэх журам

4.1 Сарын ажиллагааны үр дүнгийн хурал дараа сарын 10-ны дотор тухайн сарын эдийн засгийн үзүүлэлтүүдийг дүгнэх хэлэлцүүлэгтэй хамт хуралдана.

4.2 Сарын ажиллагааны үр дүнг дүгнэх хурлаар нэмэгдэл хөлс олгох үзүүлэлтүүдийн биелэлтийг хянан хэлэлцэж, үйлдвэрийн хэмжээний нэмэгдэл хөлс олгох хувь хэмжээг тогтооно. Сарын ажиллагааны үр дүнг дүгнэх хуралд Гүйцэтгэх захирал, Ерөнхий инженер, Санхүү, эдийн засгийн хэлтсийн дарга, Захиргаа, хүний нөөцийн хэлтсийн дарга, Үйлдвэрийн албаны дарга, Дулааны шугам сүлжээний албаны дарга, эдийн засагч, зуухан цехийн горимын инженер болон бусад хэсгийн удирдлагууд оролцоно. Нэмэгдэл хөлс олгох үзүүлэлтийн биелэлтийг эдийн засагч танилцуулна.

4.3 Алба, хэлтэс, хэсгийн инженерүүдийн нэмэгдэл хөлсийг сарын үр дүнгийн нэмэгдэл хөлс олгох журмын хавсралтанд батлагдсан үзүүлэлтээр дүгнэж хянуулна./Хавсралт №2/

4.4 Ерөнхий инженер, Санхүү, эдийн засгийн хэлтсийн дарга, Захиргаа, хүний нөөцийн хэлтсийн дарга, хөдөлмөр хамгаллын инженер нийт хэсэг, нэгж, алба, хэлтсийн сарын үр

дүнгийн нэмэгдэл хөлс олгох үзүүлэлтийг хянах бөгөөд Гүйцэтгэх захирлаар батлуулан тооцооны нягтлан бодогчид өгнө.

4.5 Сарын ажлын үр дүнгийн нэмэгдэл хөлс дүгнэх процесс нь шударга, ил тод, хамт олонд нээлттэй байна.

4.6 Ажлын зөрчил, доголдол гаргасан, компанийн хэмжээнд хэрэгжүүлж буй техникийн болон захиргааны бодлого, шийдвэрүүд, удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг биелүүлээгүй буюу хангалтгүй биелүүлсэн, ажлын үр бүтээл муутай ажилласан, хурал, нийтийн сонсгол, олон нийтийн арга хэмжээнд оролцоогүй, зөрчил гаргасан ажилтны нэмэгдэл хөлсийг дүгнэж буй удирдлагууд буюу хэсэг нэгжийн удирдлагууд бууруулах эрхтэй.

4.7 Сарын ажиллагааны үр дүнгээр олгох нэмэгдэл хөлсийг бодохдоо батлагдсан хувийн дагуу албан тушаалын ба тарифт цалингаас бодож олгоно.

4.8 Станцын ерөнхий инженер, хэсэг хариуцаагүй ИТА нарын нэмэгдэл хөлсийг дүгнэхдээ станцын нийт алба, хэлтэс, хэсгийн ИТА нарын тухайн сарын нэмэгдэл хөлсний дунджаас, бусад хэлтэс, алба, хэсэг, нэгжийн удирдлагын нэмэгдэл хөлсийг тухайн хэсэгт ажиллагсдын тухайн сарын нэмэгдэл хөлсний дунджаас тус тус тооцож олгоно.

Тав. Нэмэгдэл хөлс олгохгүй байх нөхцөлүүд

5.1 Нэмэгдэл хөлс олгох нөхцөлийг хангаагүй бол

5.2 Суралцахаар чөлөөлөгдсөн хугацаанд

5.3 Өвчтэй, цалингүй чөлөөтэй, сул зогсолттой, ажил тасалсан, эзлжийн амралттай байх хугацаанд

5.4 Дагалдан болон туршилтын хугацаагаар ажиллаж буй ажилтанд олгохгүй.

243

"Багануурын дулааны станц" ТӨХК-ийн

Гүйцэтгэх захирлын 2022 оны 12 сарын

15-ны өдрийн 1/82 р тушаалын 2-р хавсралт

"Багануурын дулааны станц" ТӨХК-ийн .....оны ....сарын

үйл ажиллагааны үр дүнгийн үзүүлэлтийн биелэлт

д/д	Үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Гүйцэтгэл хувь	Өөрчлөлт	
						Олгох хувь	Олгосон хувь
1	Дулааны эрчим хүч үйлдвэрлэлт	Гкал					
2	Дотоод хэрэгцээний ДЭХ биет	Гкал					
	Дотоод хэрэгцээний ДЭХ хувиар	%					
3	Нийт орлого:	Мян.төг					
	Цэвэр борлуулалт	Мян.төг					
	Үйл ажиллагааны бус	Мян.төг					
	Улсын татаасын орлого	Мян.төг					
4	Нийт зардал:	Мян.төг					
	Үүнээс: Үйл ажиллагааны	Мян.төг					
	Үйл ажиллагааны бус	Мян.төг					
	Удирдлагын зардал	Мян.төг					
5	Цэвэр ашиг/алдагдал/	Мян.төг					
6	Борлуулалтын 1 төг-т ногдох зардал	Төгрөг					
7	Нийт өглөгийн бууралт	Сая.төг					
		%					
8	Нийт авлагын бууралт	Сая.төг					
		%					
9	Хөрөнгө оруулалт, их засвар	Мян.төг					
10	Жишмэл түлшний зарцуулалт	Кг/Гкал					
11	Саатал-1	Тоо					
12	Байгаль орчны шинэчлэл, инновацийн асуудлыг шийдсэн байдал	Мян.төг					
13	Нэмэлт усны зарцуулалт	Тонн					
14	Хэрэглэгчдийн сэтгэл ханамж	Тоо/х					
15	Үндсэн тоноглолын ажиллагааны /график/ бэлэн байдал	Хувь					
	Нийт дүн						

Хянасан:СЭЗХ-ийн дарга

Биелэлтийг гаргасан: Эдийн засагч

244

"Багануурын дулааны станц" ТӨХК-ийн

Гүйцэтгэх захирлын 20.. оны ..-р сарын

..-ны өдрийн ..-р тушаалын ..-р хавсралт

Ажиллагсдын 20.....оны.....сарын нэмэгдэл хөлс дүгнэх үзүүлэлт

№	Үзүүлэлт	Олговол зохих хувь	Олгосон хувь	Дүгнэсэн	
				Албан тушаалын нэр	Гарын үсэг
01	Ажлын байрны тодорхойлолтод заасан ажил үүргийн гүйцэтгэл	40			
02	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль тогтоомжийн хэрэгжилт	30			
03	Удирдлагаас өгсөн үүрэг даалгаврын биелэлт	10			
04	Ажлын цаг ашиглалт	10			
05	Олон нийтийн ажилд оролцсон байдал	10			
Нийт оноо					

Танилцсан:...../ /

245

"Багануурын дулааны станц"ТӨХК-ийн

Гүйцэтгэх захирлын 2022 оны 12 сарын

15 -ны өдрийн 1/42 р тушаалын 4 -р хавсралт

"Багануурын дулааны станц" ТӨХК-ийн ажилтнуудад

жилийн ажлын үр дүнгээр нэмэгдэл хөлс олгох журам

Нэг. Ерөнхий зүйл

1.1 Компанийн бүтээмж, үр ашгийг дээшлүүлэх, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагыг хангах, технологийн аваарь саатал, зөрчилгүй ажиллах, жилийн төлөвлөгөөт алдагдлыг бууруулах, зардлыг хэмнэх, ажилтнуудын идэвх санаачлага, хариуцлагыг нэмэгдүүлэхэд энэхүү журмын зорилго оршино.

Хоёр.Жилийн үр дүнгийн нэмэгдэл хөлс тооцох, хуваарилах

2.1 Компани ашигтай ажилласан, төлөвлөгөөт алдагдлыг бууруулж болон барьж ажилласан, үйлдвэрт ноцтой осол, аваарь гараагүй нөхцөлд албан тушаалын болон сүлжээний тарифт цалинтай уялдуулан жилийн эцсийн төлөвлөгөөний биелэлт, эдийн засгийн үр ашгийн түвшинг харгалзан Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрт тусгагдсан хувь хэмжээгээр дараа оны эхний хагас жилд багтаан тухайн ажилтан албан хаагчийн жилийн үр дүнгээр 5 хүртэлх сарын жилийн үр дүнгийн нэмэгдэл хөлс олгоно.

2.2 Компани ажиллагсдад олгох үр дүнгийн нэмэгдэл хөлсний хэмжээг дараах байдлаар тогтооно. Үүнд:

-Жилийн ажлын тайлангаа 60 болон түүнээс дээш хувиар дүгнүүлсэн тохиолдолд жилийн эцсийн тайлангийн үнэлгээнд тогтоосон хувь хэмжээгээр тухайн хэлтэс, алба, хэсэг, нэгжийн ажиллагсдын жилийн үр дүнгийн нэмэгдэл хөлсийг олгоно.

2.3 Гүйцэтгэх захирал нь Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрийг үндэслэн жилийн ажлын үр дүнгийн нэмэгдэл хөлс олгох тушаал гаргана.

Гурав.Нэмэгдэл хөлс бодож олгох нөхцөл

3.1 Өндөр насны тэтгэвэрт гарсан, орон тооны цомхотголд орсон, эрүүл мэндийн хувьд гүйцэтгэж буй ажил, албан тушаалдаа тэнцэхгүй болох нь тогтоогдож ажлаас чөлөөлөгдсөн, жирэмсний амралт авсан ажилтнуудад ажилласан хугацаанд нь ногдох хэмжээгээр олгоно.

3.2 Шинээр ажилд орсон ажилтанд жинхэлснээс хойшхи ажилласан хугацаанд нь ногдох хэмжээгээр нэмэгдэл хөлс олгоно.

3.3 Нэмэгдэл хөлсийг нийт ажиллавал зохих цагаас өвчтэй, цалингүй чөлөөтэй, тасалсан, хоцорсон цагуудыг хасч жинхэнэ ажилласан цагт нь ногдох хэмжээгээр тооцож олгоно.

3.4 Байгууллагын аварга болон үйлдвэрийн үр ашгийг нэмэгдүүлсэн, шинэ бүтээл, оновчтой санал гаргасан, технологийн шинэчлэл хийж хэмнэлт гаргасан, салбар, дүүргийн хэмжээнд өндөр амжилт гаргасан ажилтнуудад жилийн үр дүнгийн нэмэгдэл хөлсийг дээд хэмжээгээр олгож болно.

3.5 Компанийн үндсэн ажилтан нас барсан тохиолдолд тухайн жилд ажилласан хугацаанд нь ногдох үр дүнгийн нэмэгдэл хөлсийг ар гэрийнхэнд нь олгоно.

3.6 Ажил, албан тушаал нь хууль болон бусад шийдвэрийн үндсэн дээр хэвээр хадгалагдаж байгаа ажилтны оронд 6 сараас дээш хугацаагаар ажиллаж байгаад ажлаас чөлөөлөгдсөн ажилтанд ажилласан хугацаанд нь ногдох хэмжээний үр дүнгийн нэмэгдэл хөлсийг олгоно.

3.7 Ажилтны сул зогсолтод хамаагдсан хугацаа, Гүйцэтгэх захирлын тушаалаар олгогдсон цалинтай чөлөөний хугацааг тухайн жилд ажилласан хугацаанд тооцно.

Дөрөв. Нэмэгдэл хөлс олгохгүй байх нөхцөл

4.1 Тухайн жилд Монгол Улсын “Хөдөлмөрийн тухай” хуулийн 80 дугаар зүйлийн 80.1.4-80.1.5 дахь заалтуудад заасны дагуу ноцтой зөрчил гаргаж, ажил олгогчийн санаачлагаар хөдөлмөрийн гэрээ цуцлагдсан бол

4.2 Байгууллагад эд хөрөнгийн хохирол учруулсан нь эрх бүхий байгууллагын шалгалтаар тогтоогдсон бол

4.3 Өвчтэй, тэтгэмжгүй чөлөөтэй, цэргийн албанд татагдсан, ажил тасалсан, суралцахаар чөлөөлөгдсөн, хүүхэд асрах чөлөөтэй хугацаанд

4.4 Улирлын чанартай ажил үүрэг гүйцэтгэж байгаад ажлаас чөлөөлөгдсөн тохиолдолд

4.5 Өөрийн хүсэлтээр ажлаас чөлөөлөгдсөн тохиолдолд

4.6 Жилийн ажлын тайлангаа 60-аас доош хувиар үнэлүүлсэн тохиолдолд